


МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Дүгэрсүрэн	Дугаар	L278
Оршин суугаа аймаг	Хөвсгөл аймаг	Оршин суугаа сум	Галт сум
Төрсөн газар	Галт сум	Төрсөн он	1929
Ажил мэргэжил	Өндөрнастан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Ширэнгэтийн дуган	Сүм хийдийн дугаар	ХӨГЛ 016
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 3	Ярилцлага авсан хүн	Д .Мөнхбат



Хөвсгөл аймгийн Галт сумын Ширэнгэтийн дуган

Мөнхбат: Тэгэхээр Дүгэрсүрэн гуайгаас дараах ярилцлагыг авахаар бид нар гол зорилгоо болгосон.За ингээд танд хандаж асуулт асуухад нэгдүгээрт та энэ орчимд байх Ширэнгэтийн дуганы одоо буурь түүрийг сахиж насаа элээж байгаагийн хувьд энэ Ширэнгэтийн дуганы ид бурхан номын үйл ажиллагаа явуулж байсан цаг үедээ хичнээн дугантай, хичнээн лам хуваргатай, шашны зан үйлийн одоо ямар ямар үйл ажиллагаа явуулдаг байсан тухай сонирхуулж ярина уу?

Дүгэрсүрэн: Өө энэ болохлээр яахав Юм хурал гэдэг нэртэй хурал байсан юм аа. Ганцхан сүмтэй л байсан газар.Гурван жан сүмтэй, хааш хаашаагаа гурван жан сүмтэй.Аа Юм хурал гэж нэртэй ийм газар байсан .Аа нэг гуч гаран дөчөөд лам нар хурсан, тийм байсан гэж мана аав тэгж байсан.Би мэдэхгүй ээ.

Мөнхбат: Тэгэхээр энэ Ширэнгэтийн дуганы гол шүтээн болсон энэ Очирваань бурхан одоо танд үе дамжиж ирж хадгалагдаж ирсэн юм байна.Та энийг одоо өнөөдөр ном журам жаягийнх нь дагуу одоо авч явахыг эрмэлздэг нь харагдаж байна.Тэгэхээр энэ дуганыхаа шүтээн болсон энэ бурхныхаа талаар та танилцуулна уу?

Дүгэрсүрэн: Аа энэ бурхныг Уваа гэдэг лам анхан хөрөг Очирваань бүтээж өөрөө зурж, бурхан зурдаг хүн байсан юм байна.Өөрөө зурж, бүтээсэн юм байна лээ. Тэгээд гэрт байж байгаад сүүлдээ тусгай байшин барьж

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

байшинд байж байгаад тэрнийхээ дараагаар сүм бариад, тэр сүм нь өвгөрөөд, дахианд нэг сүм бариулаад , тэгээд тэр сүмээр л төгссөн юм байна лээ л дээ.Очирваань шүтээнтэй ийм байсан газар.Тэгээд сэрэг Очирваань, хөрөг Очирваань хоёр Очирвааньтай.Аа сэрэг нь надад байгаа юм.Хөрөг нь Улаанбаатар хотод Чойжингийн Ичинноров гэдэг хүнд хөрөг Очирваань нь бий.Азардүвчин гэдэг хүнд байж байгаад, тэр Азардүвчингийн төрсөн ач нь хүн, тэр Ичинноров гэдэг хүн.

Мөнхбат:Тэгэхээр энэ ардын хувьсгал ялсны дараа мянга есөн зуун гучаад оны дунд үеэс эхлээд буддын шашны сүм хийдийг галдан шатааж, устгаж лам нарт нь одоо, энэ лам нарыг нь хар болгож барьж хорьж ирсэн тийм цэвүүн цаг эхэлсэн.Тэгэхээр энэ цагийн эхэн дор энэ Ширэнгэтийн хурал маань одоо хичнээн ламтай үйл ажиллагаагаа явуулж байсан, тэгээд яг тэр үеийг та одоо яаж санаж төсөөлж байна, энэ талаар та товч мэдээлэл өгнө үү?

Дүгэрсүрэн: Аа энэ болохлээр яахав, дөчөөд лам нартай хурал байсан хийд.Тэгээд л намайг одоо зургаан настай байхад, тэр чинь бар жил.За гучин хэдэн он ч байсан юм бэ дээ.Бариа тавиа үүссэн шүү дээ.Тэгээд лам нарыг нь бариад, баригдах нь баригдаад, тэгээд энэ чинь замраад сүүлдээ лам нар байхын аргагүй болоод, тэгээд л энэ бурхан сахиусаа нэг юм гаргаж далд хийж аваад, тэгээд үлдэх юм нь үлдсэн л байх шив дээ.Тэгээд хойно нь, би бага байсан.Тэгээд манайх тэр Ширэнгэтийн дуганы баруун, зүүн талын жалгат өвөлжиж байсан айл. Тэгээд тэнд байж байхад хойноосоо арав гаруй морьтой буутай улсууд ирж манайханд давхиж ирж байсан. Манай эцгийн эцэг лам байсан хүн.Манай аав чиг лам байсан хүн.Барих гэж ирж байгаа юм байж.Тэр Лувсанжамба гэдэг хүн манай аавын ахын ах хүн дээ.Тэрнийг барих тэр манай аавын аавыг барих гэж ирж байгаа юм.Байж ядаж, ингэж тэвдэцгээсэн, айсан юмнууд л байсан.Тэгсэн чинь тэгсэнгүй нэлээн удаж удаж байснаасаа л доошоо мордоод давхиад явсан.Тэр сүмийн түлхүүр байлгах ч хүн айл байхгүй, хүн айгаад л тэгээд довжоон доогуур нь сүмийн түлхүүрийг хийчихсэн байдаг байсан юм гэнэ лээ.Би бага байсан, гэхдээ сайн мэднэ би.Тэгээд л юу юугүй тэр Ширэнгэтийн дуганы зүүн хойд талаас л утаа манараад л болохоо байгаад унасан.Тэгээд л нэлээн утаа баагиж байгаад л утаа болж болж л , өнөө улсууд чинь тэгээд л давхиад яваад өгцгөөсөн.Тэгээд л би бага байсан, гүйгээд л тэр лүү, манайхантай цуг байсан айлын өнөө хүүхэдтэй хоёулаа гүйгээд л очсон.Юу ч үгүй шатаагаад хаячихсан тийм юмнууд, тэгээд л нөгөө шавар бурхан энэ тэр шатаагүйг нь бид хоёр хормойлоод аваад ирэхгүй юу даа.Тэгээд л аав ээж алдас болно гээд л хойд талын өврийн тэр хадны юунд л аваачиж хийгээд л тэгээд л байдаг байсан.Тэгээд л хамгийн сүүлд төгсгөл болоод шувтарсан газар шүү дээ.Тэгээд л яахав энэ сахиусаа, харин ганжуур, манайх чинь бүтэн ганжууртай байсан. Тэгээд бүтэн ганжуур нь хадгалагдсаар байгаад одоо Мөрөнд бий дээ, ганжуур нь. Тэр Азардүвчин гэдэг хүнд байж байгаад найман хайрцаг ном шүү дээ, зуун найман боть ном.Тэгээд Мөрөнд музейд өгсөн юм шүү дээ.

Мөнхбат: Аймгийн музейд?

Дүгэрсүрэн: Тийм, манай Мөрөнд бий дээ. Хаана нь байдаг юм, тэр музейд л байх учиртай даа.

Мөнхбат:Одоо энэ Ширэнгэтийн дуганы ном судар, бурхан шүтээнүүдээс Мөрөнгийн төв дээр байгаа тэр Гандандаржаалин хийд байна тийм ээ, тэнд одоо өвлөгдөж шилжиж очиж хадгалагдсан тийм юмнууд бий юу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Дүгэрсүрэн: Ээ дээ байхгүй байх. Байхгүй л болов уу гэж санаж байна, би. Үгүй музейд өгсөн л юм байгаа юм даа, музейд л манай ганжуур бий болов уу гэж бодож байна.

Мөнхбат: За бас таниас дахиад нэг юм сонирхоё. Энэ Ширэнгэтийн дуганд тухайн үедээ сууж байсан тэр гуч дөчөөд тооны лам нараас одоо шашны гүн ухаанд нэвтэрсэн, мэргэшсэн, тэгээд тэр нутаг олныхоо дунд түүх яриа амьд домог болж үлдсэн тийм эрдэм чадалтай лам нарын тухай одоо таньд сонсож мэдсэн тийм яриа хөөрөө байна уу?

Дүгэрсүрэн: За яагаад нэг байна.

Мөнхбат: За тэрнээсээ та хуучлаач?

Дүгэрсүрэн: За Балчинжав равжамба гэдэг хүн бол ерөөсөө монголд цуутай айхтар гэвш байсан юм гэнэ лээ. Энэ Балчинжав гуай гэдэг чинь эрдмийн далай байсан хүн юм байна лээ. Далай чойнхор вангийн Далбан хар гэж бүр овоодоо орж байсан хүн юм гэнэ лээ.

Мөнхбат: Яг энэ Ширэнгэтийн дуганд сууж байсан?

Дүгэрсүрэн: Тийм. Яг дагцлах дээрээ болоод дагцлаа хаях болоод жаахан ээрүүдүү, тэвдүүдүү тийм хүн байсан...

Мөнхбат: Сандраад?

Дүгэрсүрэн: Сандардаг маягтай. Уг нь бол ном бол их айхтар хүн байсан байгаа юм. Тэгээд зан сайтай улс алийг тэр гэхэв дээ. Энэ гавж, аранжин нар баригдсан алийг тэр гэхэв дээ.

Мөнхбат: За энэ Ширэнгэтийн хурал маань газар нутгийн байрлалын хувьд Сайн ноён хан аймгийн Далай чойнхор вангийн хошууных. Тэгэхээр Сайн ноён хан аймгийн Далай чойнхор вангийн хошууны шашны одоо гол төв нь бол Тариатын хүрээ байж?

Дүгэрсүрэн: Тариатын хүрээ.

Мөнхбат: Тэгэхээр Тариатын хүрээний одоо тэр мундаг том лам нартай очиж ном хаялцаж тийм ээ, одоо дамжаа барьж ингэж байсан лам нар одоо бишгүй л байсан байх даа, энэ дуганд?

Дүгэрсүрэн: Өө байлгүй яахав дээ. Тэнд яасан, тэр гавж равжамба болсон улс зөндөө байгаа шүү дээ. Одоо Балчинжав равжамба гэдэг хүн чинь хотод чиг л байсан хүн юм билээ. Тариатад чиг байсан хүн юм билээ л дээ. Тэгээд ер нь дээгүүрт л орж байсан хүн юм гэсэн шүү дээ.

Мөнхбат: За баярлалаа. Ингээд таны ярьсан, бид нарт өгсөн энэ үнэтэй мэдээлэл монголын түүх соёлын дурсгалыг сэргээх, 1937 оноос өмнөх монголд үйл ажиллагаа явуулж байсан буддын шашны сүм хийд хурал номын дацангийн мэдээлэлийн санг бүрдүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулна гэж бодож байна. Ингээд танд урт удаан наслахыг ерөөе, сайн сайхан байж байгаарай.